



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 0/46

Чингис хот

Ж.Ганбатыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, "Хэнтий-Ус" ХХК-ий Удирдах зөвлөлийн 2013 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Хэнтий-Ус" ХХК-ий дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 2019 оны 01 дүгээр тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалын Ганбатыг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн "Хэнтий-Ус" ХХК-ий захирлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

Ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Ганзориг	"Хэнтий-Ус" ХХК-ий мэдээлэл технологийн инженер
	Т.Алтансүвд	"Хэнтий-Ус" ХХК-ий нярав

3. Ж.Ганбатыг "Хэнтий-Ус" ХХК-ийн дотоод хяналтын ажилтнаар томилж, холбогдох тооцоог хийж дуусгахыг "Хэнтий-Ус" ХХК-ий захирал болон ерөнхий нягтлан бодогчид тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010897